



“Инвескор ББСБ” ХК-ийн 2025 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлан

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/

2025 оны 01 дүгээр сарын 01-ий өдрөөс
2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар

“Инвескор ББСБ” ХК
9010002004
MN00INV05533
77090077

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр

Монголын Хөрөнгийн Бирж

Бизнесийн үйл ажиллагааны салбар

Банк бус санхүүгийн үйлчилгээ

Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг

75,744,281 ширхэг энгийн хувьцаа
2,400,000 ширхэг давуу эрхийн хувьцаа

Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр

Бэлтгэсэн:
Нөөцийн удирдлагын газар, Санхүүгийн менежер Г. Номундарь
Хянасан:
Хөрөнгө оруулалт хариуцсан захирал С.Тулга

1. Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/

1.1 Санхүүгийн байдлын үзүүлэлт


000' MNT	(2024.12.31)	(2025.06.30)
ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	135,263,686	80,525,817
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	732,977,470	843,765,968
БДОБҮЦ-ээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	21,910,646	21,470,059

	Дериватив санхүүгийн хөрөнгө	-	506,733
	Бусад хөрөнгө	6,267,145	17,472,469
	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	2,366,355	2,796,195
	Борлуулах зорилготой хөрөнгө	3,309,939	7,983,638
	Үндсэн хөрөнгө	13,540,144	13,586,930
	Биет бус хөрөнгө	5,891,772	6,405,000
	Ашиглах эрхтэй хөрөнгө	3,223,384	3,474,012
	Гүүдвил	292,627	292,627
	Хойшлогдсон татварын хөрөнгө	1,208,394	261,635
	Нийт хөрөнгийн дүн	926,251,562	998,541,084
	ӨР ТӨЛБӨР		
	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	323,502,282	341,019,003
	Бондын өр төлбөр	124,581,919	148,470,729
	Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөр	207,389,691	196,307,639
	Хоёрдогч өглөг	1,333,156	1,108,970
	Дериватив санхүүгийн өр төлбөр	601,379	-
	Бусад өр төлбөр	9,617,962	16,244,344
	Түрээсийн өр төлбөр	3,340,561	3,226,720
	Орлогын албан татварын өглөг	7,361,200	8,658,145
	Хойшлогдсон татварын өглөг	-	239,824
	Нийт өр төлбөрийн дүн	677,728,150	715,275,374
	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		
	Хувь нийлүүлсэн хөрөнгө	17,193,952	17,193,952
	Нэмж төлөгдсөн капитал	29,820,733	29,820,733
	Давуу эрхийн хувьцаа	11,831,009	11,831,009
	Бусад нөөц	7,005,398	7,901,755
	Хуримтлагдсан ашиг	181,045,373	214,772,175
	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	14,628	467,600
	Толгой компанийн эздэд хуваарилагдах нийт гаргасан хувьцаа болон нөөц	246,911,093	281,987,225
	Хяналтын бус хувь оролцоо	1,612,319	1,278,485
	Нийт эздийн өмч	248,523,412	283,265,710
	Нийт эздийн өмч ба өр төлбөр	926,251,562	998,541,084
1.2	Орлогын тайлан		
	000' MNT	(2024.12.31)	(2025.06.30)
	Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого	224,532,959	144,996,547
	Хүү болон түүнтэй адилтгах зардал	(83,534,146)	(52,579,112)
	Хүүгийн цэвэр орлого	140,998,814	92,417,435
	Хураамж ба шимтгэлийн орлого	24,886,689	19,342,847
	Хураамж ба шимтгэлийн зардал	(448,765)	(437,868)
	Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого	24,437,924	18,904,979
	ААБҮЦ-ээр хэмжигдэх бусад санхүүгийн хэрэглүүрүүдийн цэвэр гарз	(318,823)	925,391
	Санхүүгийн хэрэглүүрүүдийн үнэ цэнийн бууралтын гарз	(18,461,799)	(34,499,863)
	Үйл ажиллагааны бусад орлого	2,405,824	1,566,654
	Үйл ажиллагааны цэвэр орлого	149,061,940	79,314,596
	Ажилчидтай холбоотой зардал	(20,069,009)	(10,935,652)
	Үндсэн хөрөнгийн элэгдэл	(1,574,041)	(1,124,045)

	Биет бус хөрөнгийн хорогдуулга		(665,734)	(370,352)
	Ашиглах эрхтэй хөрөнгийн хорогдуулга		(1,145,669)	(680,056)
	Үйл ажиллагааны бусад зардал		(11,012,036)	(8,620,135)
	Татварын өмнөх ашиг		107,291,205	57,584,356
	Орлогын албан татварын зардал		(23,852,551)	(15,553,744)
	Тайлант жилийн цэвэр ашиг		83,438,658	42,030,612
1.3	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Нэгтгэсэн байдлаар компанийн нийт эздийн өмч 2024.12.31 байдлаар 248.5 тэрбум төгрөг байсан бөгөөд 2025.06.30 байдлаар болж 283.3 тэрбум төгрөг, 34.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нэмэгдсэн дүнд 2025 оны эхний хагас жилийн цэвэр ашиг 42 тэрбум төгрөг, 0.4 тэрбум төгрөгийн нэмэлт орлого, 0.4 тэрбум төгрөгийн давуу эрхийн хувьцаа багтаж байгаа бол 6.8 тэрбум төгрөгийн ногдол ашиг болон хувьцаа худалдан авсантай холбоотой тохируулга 1.4 тэрбум нь бууруулах нөлөө үзүүлсэн байна.		
1.4	Мөнгөн гүйлгээний тайлан	Нэгтгэсэн байдлаар үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (66.4) тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (1.1) тэрбум төгрөг, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 12.8 тэрбум төгрөг бүгд нийлээд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 80.5 тэрбум төгрөг болсон байна.		
2.	Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт - Хавсаргав			
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт - Хавсаргав			
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	- Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа (9.6% Хангасан) - ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа (23.0% Хангасан) - ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа (9.6% Хангасан) - Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (21.6% Хангасан) - Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (11.9% Хангасан) - Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (-0.2% Хангасан)		

		- Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (74.3% Хангасан) - Өрийн бичгийн зохистой харьцаа (29.4% Хангасан) - Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа (1.3% Хангасан) *Тусдаа тайлангаар
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа (20.1% Хангасан) - Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа (23.1% Хангасан) - Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа (25.3% Хангасан) - Өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа (30.5% Хангасан) *Тусдаа тайлангаар
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	Зээлийн багц өнгөрсөн оны жилийн эцэстэй харьцуулахад нийт 15.1%-р өсөж 843.8 тэрбум төгрөг хүрсэн байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 573 ББСБ-ын 5.7 их наядын зээлийн багцын 13.0% хувийг “Инвескор ББСБ” ХК бүрдүүлж байна. Зээлийн багцыг бүтээгдэхүүнээр ангилахад дараах бүрэлдэхүүнтэй байна. - Бизнесийн зээл-24.1% - Автомашины зээл-36.5% - Хэрэглээний зээл-5.0% - Дижитал зээл-34.4% Компани цаашид хэрэглээний зээлийг бүрэн автоматжуулах, бизнесийн зээл рүү илүү төвлөрч жижиг дунд бизнес эрхлэгчдээ дэмжин ажиллах бодлого баримталж байна.
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгээгүй. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ 2025 оны эхний хагаст нийт 12 сонирхлын зөрчилтэй хэлцлийг Инвескор ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан “Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл байгуулах журам”-ын дагуу ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо дүгнэлт гаргаж, сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүд танилцаж баталсан байна. Үүнд, холбоо хамаарал бүхий компаниудаас үйлчилгээ авах болон зээл олгохтой холбоотой хэлцэл, зэргэлдээ компаниудтай нийт 11 хэлцэл, толгой компаниас үйл үйлчилгээ авахтай холбоотой 2 хэлцэл, охин компанид зээл олгох талаарх 1 хэлцлийг хийсэн байна.	

5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл
	Тайлант хугацаанд олон нийтэд хувьцаа санал болгоогүй
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл
	Хавсаргав – 2025 оны санхүү, үйл ажиллагааны тайлангаас харна уу.
6.	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл
	Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ийн хавсралт 1-д заасан тайлангийн маягт болон Монголын хөрөнгийн биржийн 2022 оны 6-р сарын 9-ний өдөр баталсан үнэлгээний аргачлалын дагуу “Инвескор ББСБ” ХК-ийн Компанийн засаглалын кодексн хэрэгжилтийн үнэлгээний тайлан 2025 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн байдлаар тайлагнагдсан. Компанийн засаглалын кодексн хэрэгжилтийн үнэлгээний тайланг www.invescore.mn хуудсанд нээлттэй байршуулсан болно.
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо: Овог, нэр: Д.Баясгалан Албан тушаал: Гүйцэтгэх захирал Гарын үсэг:	
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: Овог, нэр: Б.Буд Албан тушаал: ТҮЗ-ын Нарийн бичгийн дарга Гарын үсэг:	



InvesCore FI

Listed on
**LONDON
STOCK
EXCHANGE**

2025

Оны эхний хагас
Санхүү, Үйл Ажиллагааны
Тайлан

АГУУЛГА

1 Онцлох үйл явдлууд

2 Үйл ажиллагаа

Покет дижитал зээл

Төв Азийн үйл ажиллагаа

Дижиталчлал

Кибер аюулгүй байдлын стратеги

Байгууллагын соёл

3 Санхүүгийн үр дүн

Гадаад эх үүсвэр

Хувьцаа

4 Тогтвортой хөгжил

5 Компанийн засаглал

Төлөөлөн удирдах зөвлөл

ТУЗ-ийн үйл ажиллагаа



Лондонгийн Хөрөнгийн Биржид

Инвекор Санхүүгийн Групп нь Лондоны Хөрөнгийн Биржид бүртгэлтэй анхны Монгол санхүүгийн компани болж, олон улсын зах зээлд шинэ алхам хийж баярт мөчөө харилцагчид, түншүүд болон хамтран ажиллагсадтайгаа хамт тэмдэглэлээ.



"ТОП-100 Аж Ахуйн Нэгж"- ээр шалгарлаа

Инвекор Санхүүгийн Байгууллагыг Монгол Улсын Засгийн газар болон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас "ТОП-100 АЖ АХУЙН НЭГЖ"-ийн нэгээр анх удаа шалгарууллаа.



Орон нутгийн тэлэлт

Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх үндсэн зорилтуудынхаа хүрээнд Дорноговь аймагт өөрийн салбараа нээж, орон нутгийн бизнесийг хөгжүүлэх чиглэлд ажиллаж байгаа ба тун удахгүй Өмнөговь аймагт салбараа нээхээр ажиллаж байна.



Киргиз улсад дахин нэг салбар нээлээ

Киргиз улс дахь Инвескорын охин компани Чуй бүсийн Токмок хотод шинэ салбараа байгуулав.



"Харилцагчийг хамгаалах зарчим"-ын Silver түвшний үнэлгээтэй сертификат авлаа

Бид 2022 оноос хойш Харилцагчийг хамгаалах зарчмуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, үе шаттай сайжруулж ирсэн бөгөөд эдгээр зарчмуудын хэрэгжилтийг баталгаажуулахаар олон улсын түвшний MFR үнэлгээний агентлагаар хөндлөнгийн аудит хийлгэж SILVER түвшинд үнэлэгдлээ.



RioTinto × **InvesCore FI**


Жижиг, дунд бизнесийг дэмжих хөтөлбөр

Инвескор Санхүүгийн Групп болон Rio Tinto-той хамтран хэрэгжүүлж буй "Жижиг, дунд бизнесийг дэмжих хөтөлбөр"-ийн хаалтын үйл ажиллагаа амжилттай болж өндөрлөлөө.



Салбарын онцлогт тохирсон санхүүжилтийн шийдлүүд

Эдийн засгийн салбаруудын онцлогт нь тохируулан хамтрагч байгууллагуудтай хамтран хөдөө аж ахуйг дэмжсэн бүтээгдэхүүний зээл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах зээл, Монголын хөрөнгийн биржийн ТОП 20 индексийн хувьцааг барьцаалсан зээл, болон импортын зээл зэрэг бусад олон төрлийн бүтээгдэхүүнийг харилцагчийнхаа эрэлт хэрэгцээнд тулгуурлан нэвтрүүлээд байна.



Core Synergy VIP customer event

Компанийн стратегийн харилцагч болох VIP үйлчлүүлэгчдэдээ бизнесээ өргөжүүлэх, шинэ боломжуудыг нээхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор цуврал нэтворкинг арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээ нь салбар бүрийн гүйцэтгэх удирдлагын түвшний төлөөллүүдийг оролцуулан, туршлага солилцох, сүлжээг өргөжүүлэх, харилцан ашигтай хамтын ажиллагааг эхлүүлэх боломжийг бүрдүүлдгээрээ онцлогтой юм.



pocket **ZERO**

Pocket Zero Expo 2025

BNPL үйлчилгээг сурталчлан таниулах зорилготойгоор жил бүр уламжлал болгон хэрэгжүүлдэг арга хэмжээг "Хайр ба Гэр бүл" концепцийн хүрээнд амжилттай зохион байгуулав.

pocket



 pocket

Халаас дүүрэн инээмсэглэл

5 жилийн ойг хэрэглэгч, харилцагч, ажилтнууддаа баяр хүргэсэн байдлаар зохион байгуулав.

pocket



Төв Азийн үйл ажиллагаа



InvesCore KG - Киргиз улс


Зээлийн Багц: **61,5 тэрбум ₮**

Салбарын тоо: **7**

Гадаадын болон дотоодын санхүүгийн байгууллага, олон улсын сангуудаас нийт 2.7 сая долларын санхүүжилт татсан ба Lendahand-аас 1.5 сая ам.долларын санхүүжилт авах гэрээнд гарын үсэг зурлаа.

Чүй бүсийн Токмок хотод шинэ салбараа байгуулав.

Зээлийн багц (тэрбум төгрөг)




InvesCore KZ - Казахстан улс

Зээлийн Багц: **20,5 тэрбум ₮**

Салбарын тоо: **1**

Казахстан Улсын зах зээлд үйл ажиллагаа явуулж буй 213 ББСБ-аас Төв банкны эх сурвалжит мэдээллээр хөрөнгийн хэмжээгээр өмнөх үеийн 70 дугаар байраас 18 байр урагшилж 52 дугаарт эрэмбэлэгдэв.

Зээлийн багц (тэрбум төгрөг)






Дижиталчлал

2025 оны эхний хагас жилд бид дижитал экосистемээ хөгжүүлэх томоохон санаачилгуудыг хэрэгжүүлж, түүний гүйцэтгэл болон хэрэглэгчийн оролцоог сайжруулах шинэчлэлээр төвлөрөн ажиллав.



Кибер аюулгүй байдлын стратеги

Харилцагчийн мэдээллийн хамгаалалт бол бидний тэргүүлэх зорилт тул өгөгдлийн аюулгүй байдлыг бэхжүүлэх олон арга хэмжээ авч, томоохон хөрөнгө оруулалт хийсэн.



Байгууллагын соёл



Coffee *With* Core

Дотоодын менежментийн эрхмүүдийн амжилтын түүх

Инвектор Санхүүгийн Группийн удирдлагын багийн эрхмүүдийн ажлын гараа болоод амжилтын түүхээс дурдсан цуврал контент амжилттай цацагдаж эхэллээ.



COR_XP=RIENCE

Амжилттай яваа бизнес эрхлэгчдийн түүх

Бизнесийн амжилтаа 0-ээс эхэлсэн эрхмүүдийн амжилтын түүх болон үнэт зөвлөгөөг түгээх зорилгоор бүтээгдсэн цуврал контент цацагдаж эхэллээ.



#AllStaffMeeting25

Нийт ажилтнуудын хурал 2025

2024 оны амжилтаа бататгаж 2025 оны гол зорилтуудаа тодорхойлсон Нийт ажилтнуудын хурлыг амжилттай зохион байгууллаа.



“ З О Г С О Л Т Г Ү Й ”


Зогсолтгүй баримтат нэвтрүүлэг

Инвектор Санхүүгийн Группийн олон улсад салбар компаниудаа байгуулж, өргөжин тэлж буйг харуулсан нэвтрүүлгийг Централ ТВ-тэй хамтран амжилттай олон нийтэд цацагдаж дууслаа.




Санхүүгийн үр дүн /аудитлагдаагүй/


Нийт актив
тэрбум төгрөг




Зээлийн багц
тэрбум төгрөг



Нийт орлого
тэрбум төгрөг



Цэвэр ашиг
тэрбум төгрөг



Гол харьцаа үзүүлэлтүүд

	2023.06	2024.06	2025.06
Хөшүүрэг	3.2	3.8	3.5
Зээл, активын харьцаа	83%	74%	87%
Чанаргүй зээлийн харьцаа	5.6%	5.6%	7.3%
Өөрийн хөрөнгийн өгөөж	27%	37%	30%
Активын өгөөж	8.5%	9.7%	8.4%

*Нэгтгэсэн тайлан

Гадаад эх үүсвэр



Triple Jump

Инвекор Санхүүгийн Байгууллага нь Нидерландын Triple Jump санхүүгийн байгууллагаас 5 сая ам.долларын зээлийн санхүүжилтийг амжилттай хүлээн авлаа.

Triple Jump нь ногоон болон тогтвортой хөрөнгө оруулалтын чиглэлээр дэлхийд тэргүүлэгч хөрөнгө оруулалтын менежментийн компани юм.



Инвекор Санхүүгийн Байгууллага нь олон улсын EMF Microfinance Fund хөрөнгө оруулалтын сангаас 3 сая ам.доллартай тэнцэх хэмжээний нэмэлт зээлийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүллээ.

Ингэснээр тус сангаас Инвекор Санхүүгийн Байгууллагад олгосон нийт санхүүжилтийн хэмжээ 16 сая ам.доллар болж байна.


Хувьцаа



Ногдол ашиг

“Инвекор ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 08 тоот тогтоолоор 2024 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 60 төгрөгийг ногдол ашгийг энгийн хувьцаа эзэмшигч нартаа хуваарилахаар шийдвэрлэсний дагуу 2025 оны 4 сарын 23-ны өдөр нийт 4,250,635,908 төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршууллаа.

Хуваарилсан ногдол ашгийн дүн (сая төгрөг)





Тогтвортой хөгжил



Ногоон зээлийн хамтын ажиллагаа

2025 оны эхний хагаст Инвескор ББСБ нь ногоон зээлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилтын хүрээнд эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгч байгууллагуудтай стратегийн түншлэлүүдийг бий болголоо. Тухайлбал, эм, эмнэлгийн тоног төхөөрөмж болон барилгын материалын үйлдвэрлэл, нийлүүлэлт эрхэлдэг аж ахуйн нэгжүүдтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж эхэлсэн нь бидний тогтвортой санхүүжилтийн зорилтод хүрэхэд түлхэц болж байна.



Тогтвортой эх үүсвэр

Инвескор ББСБ ХК нь хүртээмжтэй бөгөөд хариуцлагатай санхүүжилтийг дотоодын зах зээлд түгээж, нийгэм, эдийн засаг болон байгаль орчинд эерэг өөрчлөлт авчрах төсөл, санаачилгуудыг дэмжих зорилгын хүрээнд "Global Climate Partnership Fund" (GCPF), "Global Gender Smart Fund" (GGSF), мөн Нидерландын FMO банк зэрэг тогтвортой санхүүжилтийн сангуудаас ногоон болон жендерийн тэгш байдлыг дэмжих санхүүжилтийн эх үүсвэрүүдийг татан төвлөрүүлэхээр төлөвлөж, холбогдох хэлэлцээрийн бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. Уг эх үүсвэрээр дамжуулан бид санхүүгийн үйлчилгээний цар хүрээг өргөжүүлж, байгаль орчны хамгаалал, нийгмийн тэгш оролцоонд суурилсан тогтвортой санхүүгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулахаар зорьж байна.



Тогтвортой байдлын туршлага

ТоС холбооны ББСБ-уудын мэргэжлийн зөвлөлийн ээлжит уулзалтын хүрээнд Инвескор ББСБ ХК нь тогтвортой хөгжлийн бодлого, түүний хэрэгжилт болон олон улсын стандартад нийцсэн тайлагналын туршлагаа бусад гишүүн байгууллагуудтай хуваалцлаа.



Компанийн засаглал

Хувьцаа эзэмшлийн бүтэц ба хувьцаа эзэмшигчдийн оролцоо

“Инвекор ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшлийн бүтэц

- **Эс Ай Би Жэй Капитал ХХК** **80.49%**
- **Олон нийт** **19.51%**

Компанийн засаглалын хүрээнд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэж, хариуцлагатай, ил тод, нээлттэй үйл ажиллагааг хангах үүднээс хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг тогтмол зохион байгуулж, стратегийн ач холбогдол бүхий шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн оролцоотойгоор шийдвэрлэдэг.

2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангах зорилгоор танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгууллаа. Энэхүү хуралд саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид 90.11%-ийн ирцтэйгээр оролцсон ба дараах шийдвэрүүдийг 99.98%-ийн саналаар баталлаа. Үүнд:

- 2024 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх TVЗ-ийн дүгнэлт;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох;
- 2025 оны үйл ажиллагааны төсвийг батлах;
- 2023 оны 4 дүгээр сарын 14-ний хурлын А/04 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах

Компанийн Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдэд 100 ширхэг гацуур модны үрсэлгээ бэлэглэж, тарих боломжийг олгосон нь байгаль орчинд ээлтэй байх Компанийн үнэт зүйлсийг түгээх гол зорилготой байлаа.





Төлөөлөн удирдах зөвлөл

2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 7 гишүүнийг улируулан томилж, шинээр 2 гишүүнийг сонгосноор ТУЗ нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр сонгогдсон.

ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг томилоход гишүүдийн мэргэжлийн туршлага, хараат бус байдал, олон талт байдлыг хангах зарчмуудыг харгалзан үзсэн бөгөөд уг үйл явцад ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн хүрээнд үнэлгээ, дүгнэлт хийж Хувьцаа эзэмшигчдийн хуралд санал оруулсан болно.



Б. Анхболд

Төлөөлөн удирдах
зөвлөлийн дарга



Д. Баясгалан

Төлөөлөн удирдах
зөвлөлийн гишүүн



Хирохито Намики

Төлөөлөн удирдах
зөвлөлийн гишүүн



Р. Пүрэв

Төлөөлөн удирдах
зөвлөлийн гишүүн



Ш. Эрдэнэбат

Төлөөлөн удирдах
зөвлөлийн гишүүн



Б. Энхмарал

Төлөөлөн удирдах
зөвлөлийн гишүүн



Ч. Хашчулуун

Төлөөлөн удирдах зөвлөлийн
хараат бус гишүүн



Д. Энхбат

Төлөөлөн удирдах зөвлөлийн
хараат бус гишүүн



Ч. Өнөржаргал

Төлөөлөн удирдах зөвлөлийн
хараат бус гишүүн



ТУЗ-ийн үйл ажиллагаа

Компанийн засаглалын хүрээнд тайлант хугацаанд Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) нь компанийн үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлагатай байдлыг хангах зорилгоор холбогдох дүрэм, журам, бодлогыг мөрдөж ажилласан бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын гишүүдийг Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекс-т нийцүүлэн бүрдүүлсэн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод



ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан

	Хуралдсан байдал
ТУЗ-ийн хурал	- Эрсдэлийн аппетит батлах - ТУЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлах - Ногдол ашиг тараах шийдвэр - Хувьцаа эзэмшигчийн хурал зохион байгуулахтай холбоотой шийдвэрүүд - ТУЗ-ийн дэргэдэх гишүүд томилох - Сонирхлын зөрчилтэй хэлцэлд зөвшөөрөл олгох - Олон улсын сангуудаас эх үүсвэр татах гэх мэт асуудлаар нийт 17 удаа хуралдаж холбогдох шийдвэрүүдийг гаргаж ажилласан байна.
Аудитын хороо	- Дотоод аудитын дүрэм, журам батлах - Дотоод аудитын 1-р улирлын тайлан - Хөндлөнгийн аудитыг сонгох, хөндлөнгийн аудитын үр дүнд дүгнэлт гаргах - Сонирхлын зөрчилтэй хэлцэлд дүгнэлт гаргах гэх мэт асуудлаар нийт 8 удаа хуралдаж Төлөөлөн удирдах зөвлөлд дүгнэлт хүргүүлж ажилласан байна.
Эрсдлийн удирдлагын хороо	- Эрсдэлийн тайлан - ТУЗ-өөс олгогдсон эрх хэмжээнийх хүрээнд зээл шийдвэрлэх асуудлаар нийт 13 удаа хуралдаж холбогдох шийдвэр, дүгнэлтүүдийг гаргаж ажилласан байна.
Нэр дэвшүүлэх хороо	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалттай холбоотой асуудлаар 1 удаа хуралдсан байна.

*2025 оны эхний хагаст Цалин урамшууллын хороо болон Тогтвортой байдлын хороо хуралдаагүй болно.

InvesCore FI



+976 7709-0077

info@invescore.mn

www.invescore.mn